

**БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ ХӨГЖЛИЙН
БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ ОРОН ТООНЫ БУС ДЭД ЗӨВЛӨЛИЙН
2023 ОНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

№	Үйл ажиллагаа	Хүрэх түвшин	Шалгуур үзүүлэлт/ тоо хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Биелэлт	Хувь
<p>Зорилго: Хөгжлийн бэрхшээлтэй хүний ажиллаж, амьдрах орчин, нөхцөлийг сайжруулах, орон сууц, олон нийтийн барилга байгууламж, дэд бүтцийн байгууламжийг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагад нийцүүлэх, салбарт тэдний оролцоо, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд холбогдох арга хэмжээг авах. /Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 8, 9, 17 дугаар зүйл/</p>							
<p>Зорилт 1. Дэд зөвлөлийн үйл ажиллагааг хүртээмжтэй явуулах, хөгжлийн бэрхшээл, нийтийн хүртээмжийн талаар мэдлэг ойлголт түгээх, нөлөөллийн ажлыг зохион байгуулах:</p>							
1.	1.1 Дэд зөвлөлийн ээлжит хуралдааныг зохион байгуулах, үйл ажиллагааны тайлан, төлөвлөгөөг боловсруулан батлуулах, холбогдох байгууллагад хүргүүлж, мэдээлж ажиллах.	<ul style="list-style-type: none"> - Хуралдааныг зохион байгуулж, тайланг хэлэлцүүлж, төлөвлөгөөний төслийг танилцуулж, гишүүдээс санал авч тусгасан байна. - Төлөвлөгөөг батлуулан холбогдох байгууллагуудтай хамтран төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллан, хэрэгжилтийг холбогдох байгууллагуудад хугацаанд хүргүүлсэн байна. 	<ul style="list-style-type: none"> -Хуралдааны тоо; - Батлагдсан төлөвлөгөө, хэрэгжилтийн хувь 	I-IV улиралд	БХБЯ, ХНХЯ, ГЗБГЗЗГ, БХТ ТӨААТҮГ, ТББ-ууд	<ul style="list-style-type: none"> - Дэд зөвлөлийн хурлыг 2023 оны 01 дүгээр сарын 05 -наас 08-ны өдрүүдийн хооронд танхимаар 2 удаа, цахимаар 4 удаа хуралдаж 2022 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцүүлж, 2023 оны төлөвлөгөөний төслийг 2023 оны төлөвлөгөөний төслийг хэлэлцэж, санал зөвлөмж тусган Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөлийн 2023 оны ажлын төлөвлөгөөг 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдөр батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан. - Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг I улирлын байдлаар гарган ХНХЯ-нд 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 03/900 дугаар албан бичгээр болон 	100

					<p>boloroo@mlsp.gov.mn цахим хаягаар хүргүүлсэн. Мөн төлөвлөгөөний биелэлтийг III, IV улирлын байдлаар гарган purevsuren@mlsp.gov.mn, boloroo@mlsp.gov.mn цахим хаягаар хүргүүлсэн.</p> <p>- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас ирүүлсэн албан бичгийн дагуу Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын Конвенцын зүйл, заалтын хэрэгжилт, НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хорооноос Монгол Улсад 2015 онд ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилт, НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хэрэгжилтийн мэдээллийг холбогдох асуудлын хүрээнд 2020 оноос хойш хийсэн бодлого, үйл ажиллагааны талаарх мэдээллийг холбогдох газруудаас авч нэгтгэн, boloroo@mlsp.gov.mn цахим хаягаар 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдөр хүргүүлэв.</p> <p>- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах үндэсний зөвлөлийн 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн хуралд Барилга, хот байгуулалтын яамны удирдлагуудыг холбогдох мэдээллийг өгч ажилласан.</p> <p>- Мөн НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хороонд 2019 онд хүргүүлсэн тайлан, НҮБ-аас ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилт, 54 асуултын дагуу холбогдох тайлан, мэдээлэл,</p>
--	--	--	--	--	--

					<p>хэрэгжилтийг гарган ХНХЯ-ны Хүн амын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтний Bologoo@mlsp.gov.mn цахим хаягаар 2023 оны 05 дугаар сарын 30-ны болон тайлан сайжруулан ХНХЯ-ны Хүн амын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтний Bologoo@mlsp.gov.mn цахим хаягаар 2023 оны 06 дугаар сарын 28-ны өдөр хүргүүлсэн.</p> <p>- Монгол Улсын засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 281 дүгээр тогтоол, Барилга хот байгуулалтын сайдын 2023 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн Б/118 дугаар тушаалын дагуу Швейцарын Холбооны Улсын Женев хотноо 2023 оны 08 дугаар сарын 13-20-ны өдрүүдэд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Конвенцын Хорооны 29 дүгээр хуралдаанд “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц”-ын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Засгийн газрын ээлжит 2 болон 3 дугаар тайланг хэлэлцүүлж, хамгаалах үүрэг бүхий бүрэлдэхүүнд Барилга, хот байгуулалтын яамны Барилга, инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга бөгөөд мөн яамны дэргэдэх Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөлийн Дэд дарга Д.Гантулга томилолтоор ажиллаж, Монгол Улс</p>
--	--	--	--	--	---

					<p>тайлангаа амжилттай хэлэлцүүлж, хамгаалсан.</p> <p>- “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зөвлөлийн ажиллах журам”-ын төсөлд санал боловсруулж 2023.11.08-ны өдрийн 1/4061 дугаар албан бичгээр ХНХЯ-д хүргүүлсэн.</p> <p>- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 01 –ний өдрийн хуралдаанаар Зөвлөлийн даргаас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллагууд, Яамдын дэд зөвлөлүүдтэй, уулзах уулзалтын хуваарь гарган уулзалт зохион байгуулах мөн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний санал танилцуулахыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зөвлөлийн ажлын албанд үүрэг, чиглэл өгсөн.</p> <p>- Энэ хүрээнд уулзалтын хуваарийн дагуу хурлын бэлтгэл ажлыг хангаж Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөлтэй уулзах уулзалтыг 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулан ажиллаа.</p> <p>- Уулзалтад дэд зөвлөлийн дэд даргаар ахлуулсан нийт 8 гишүүд, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг</p>
--	--	--	--	--	---

						<p>хангах зөвлөлийн ажлын албанаас ХНХЯ-ны Хүн амын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга С.Тунгалагтамираар ахлуулсан нийт 9 гишүүн оролцсон.</p> <p>- Тус уулзалтаар Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зөвлөлийн 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилт, 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах ажлын санал, Тухайн салбарт хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах чиглэлээр тулгамдсан асуудал, шийдлийн талаар санал солилцлоо.</p>	
2.	<p>1.1. Салбарын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, аюулгүй байдал, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлд сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулах.</p>	<p>- Салбарын инженер техникийн ажилтнуудад мэргэшлийн зэрэг олгох болон бусад богино хугацааны сургалтын хөтөлбөрт Хөгжлийн бэрхшээл, нийтийн хүртээмж, нийгмийн хандлага, харилцаа, хөгжлийн талаар болон Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлт, ажил олгогч нар ажлын байрыг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн онцлог</p>	<p>- Сургалт, нөлөөллийн ажлын тоо; - Сургалтад хамрагдсан хүмүүсийн тоо.</p>	I-IV улиралд	БХБЯ, ХНХЯ, ГЗБГЗЗГ, БХТ ТӨААТҮГ, ТББ-ууд, ААН-үүд	<p>- Салбарын инженер техникийн ажилтнуудад мэргэшлийн зэрэг олгох болон бусад богино хугацааны сургалтын хөтөлбөрт Хөгжлийн бэрхшээл, нийтийн хүртээмж, нийгмийн хандлага, харилцаа, хөгжлийн талаар болон Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлт, ажил олгогч нар ажлын байрыг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн онцлог байдалд нийцүүлэх, холбогдох норм ба дүрэм, хууль, тогтоомж, холбогдох бодлого, эрх зүйн орчны талаарх мэдлэг мэдээлэл олгох чиглэлийн сургалтуудыг тусгасан дараах сургалтуудыг зохион байгуулан ажилласан. Үүнд:</p> <p>- Барилгын салбарын норм, нормативыг сурталчлах, сургалт</p>	100

		<p>байдалд нийцүүлэх, холбогдох норм ба дүрэм, хууль, тогтоомж, холбогдох бодлого, эрх зүйн орчны талаарх мэдлэг мэдээлэл олгох чиглэлийн сургалтуудыг тусгасан байна.</p> <p>- Сургалтад яам, харьяа байгууллагууд, аж ахуйн нэгжүүдийг хамруулсан байна.</p>				<p>зохион байгуулах ажлын хүрээнд БХБЯ, БХТ Хууль эрх зүй, норм нормативын баримт бичгийг танилцуулах сурталчлах, сургалтын 5 өдрийн аяныг 2023 оны 06 дугаар сарын 14-нөөс 20-ны өдрүүдэд “Монголын барилгын зураг төсөл зохиогчдын холбоо” ТББ-тай хамтран зохион байгуулсан. Тус аяны хүрээнд сургалтыг цахим болон танхимаар үнэ төлбөргүй зохион байгуулсан бөгөөд салбарын инженер техникийн ажилтан албан хаагчдад 5 кредит цаг олгож, гэрчилгээ олгосон. Сургалтад давхардсан тоогоор 456 салбарын инженер, албан хаагчид хамрагдаж, 1 багц цаг хангасан-35, 2 багц цаг хангасан-29, 3 багц цаг хангасан -16, 4 багц цаг хангасан -18, 5 багц цаг хангасан-37 мэргэжилтэн, албан хаагч, нийт 135 инженер техникийн ажилтанд гэрчилгээ олгосон байна.</p> <p>- Барилга, хот байгуулалтын сайдын 2023 оны 199, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын А/117 дугаар хамтарсан тушаалаар 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд “Барилга байгууламжийн чанар, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн” 3 сарын аяныг зохион байгуулсан.</p> <p>Аяны хүрээнд “Хөдөлмөрийн эрүүл ахуйн ойлголт, ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ”, “Зураг төсөл боловсруулалт, чанарын</p>	
--	--	--	--	--	--	--	--

						<p>байдал”, “Аюултай тохиолдлын менежмент”, “Өргөх байгууламжийн техникийн аюулгүй ашиглалт” зэрэг сэдвийн хүрээнд ажил олгогч нарт зориулан сургалтыг 2023 оны 10 дугаар сарын 06-ны, 11 дүгээр сарын 30-ны өдрүүдэд тус тус “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ-т зохион байгуулсан.</p> <p>- “Барилга байгууламжийн чанар, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй аян”-ы хүрээнд Сүхбаатар аймгийн барилга угсралтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа ажил олгогч, ажилтнуудад зориулсан “Барилгын салбарт ХАБЭА-г хангах нь” сэдэвт сургалт 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдөр Сүхбаатар, 10 дугаар сарын 16-нд Өмнөговь аймагт тус тус зохион байгуулсан.</p> <p>- Барилгын салбарын норм, нормативыг сурталчлах, сургалт зохион байгуулах ажлын хүрээнд БХБЯ, БХТ Хууль эрх зүй, норм нормативын баримт бичгийг танилцуулах сурталчлах ажлын хүрээнд: Эхний хагас жил:</p> <ol style="list-style-type: none"> 1. Орон сууцны барилгын нэгж хүчин чадалд ногдох материал, машин, механизм, ажиллах хүчний зардлын норматив баримт бичиг, 2. “Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилгын төлөвлөлт” /БНБД 31-24-22/,
--	--	--	--	--	--	---

					<p>3. “Ерөнхий боловсролын сургуулийн барилгын төлөвлөлт” /БНБД 31-25-22/;</p> <p>4. Орон сууцны барилгад тавигдах ерөнхий шаардлага,</p> <p>5. Барилгын салбарын эрх зүйн актын эмхэтгэл 2023,</p> <p>6. Барилга, дэд бүтэц болон үйлдвэрийн барилга байгууламжийн инженерийн үйлчилгээ. Нэр томъёо ба тодорхойлолт. MNS EN 16310:2023 баримт бичгүүдийг https://mcis.gov.mn/ цахим хуудсанд байршуулж нийтэд сурталчилсан.</p> <p>- Мөн 2022 онд батлагдсан Барилгын хийц, бүтээц, төлөвлөлтийн норм, нормативын баримт бичгийн талаар танилцуулга хичээл зааж бичлэг хийлгэсэн. Барилгын салбарын хууль эрх зүй сэдэвт сургалтад шинээр батлагдсан нормативын танилцуулгын хүрээнд 2021, 2022 онд батлагдсан төлөвлөлтийн норм дүрмүүдээр хичээл бэлтгэж 45 минутын бичлэг хийлгэсэн.</p> <p>- “Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм” /БНБД 30-01-04/ барилгын норм ба дүрмийн шинэчлэн боловсруулсан төслийн хэлэлцүүлгийг 2023.05.23-ны өдөр зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт төсөл боловсруулж буй зөвлөх багийн бүрэлдэхүүн, салбарын зургийн байгууллага, ТББ-ууд зэрэг нийт 60</p>	
--	--	--	--	--	--	--

					<p>хүн оролцсон. Хэлэлцүүлгээс гарсан санал, зөвлөмжийг төсөлд тусгасан.</p> <p>Сүүлийн хагас жил:</p> <ul style="list-style-type: none"> - Батлагдаж гарсан барилгын норм дүрмийг постер байдлаар бэлтгэн Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын цахим хуудас, олон нийтийн сүлжээнд байршуулан баримт бичгүүдийг сурталчлан ажилласан байна. Үүнд: <ul style="list-style-type: none"> - Барилга байгууламжийн галын аюулгүй байдлын техникийн зохицуулалтын -1ш; - Барилга байгууламжийн аюулгүй байдлын техникийн зохицуулалтын-1ш; - "Ган бүтээц" /БНБД 53-03-22/ - 11; - "Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилгын төлөвлөлт" /БНБД 31-24-22/-7ш; - "Ерөнхий боловсролын сургуулийн барилгын төлөвлөлт" /БНБД 31-25-22/-4ш; - "Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх" /БНБД 22-01-21/ - 5 постерыг тус тус байршуулсан байна. <p>Видео бичлэг:</p> <ul style="list-style-type: none"> - "Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүртээмжийг төлөвлөх" /БНБД 35-01-22/-3 удаагийн цуврал бичлэг, хичээл, - Норм нормативын төсөлд санал өгөх зааварчилгаа-1 удаагийн видео бичлэгийг олон нийтийн сүлжээнд байршуулсан.
--	--	--	--	--	--

					<p>- 2023.11.17-ны өдөр "Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх" /БНБД 22-01-21/ норм ба дүрэмд эмнэлгийн барилга төлөвлөх тухай постер байршуулан баримт бичгүүдийг сурталчлан ажилласан байна.</p> <p>- "Монголын барилгын материал үйлдвэрлэгчдийн холбоо" ТББ-аас зохион байгуулсан ИТА-ын сургалтад "Барилга байгууламжийн норм нормативын баримт бичгийн ерөнхий тогтолцоо, шинээр батлагдсан баримт бичиг" сэдвээр мэдээлэл өгөх 3 цагийн сургалтыг онлайнаар шинээр батлагдсан "Барилга байгууламжийн галын аюулгүй байдлын техникийн зохицуулалт", "Барилга байгууламжийн аюулгүй байдлын техникийн зохицуулалт"-ын баримт бичгийг сурталчилсан.</p> <p>- БХТ ТӨААТҮГ-ын олон нийтийн сүлжээнд байршуулсан нийт 57-н постер мэдээлэл, танилцуулгын сурталчилгааг 1,899 удаа сэтгэгдэл үлдээн санал өгч, 3,213 удаа share хийж түгээсэн байна.</p> <p>БХТ ТӨААТҮГ-ын https://mcis.gov.mn/ вебсайтад байршуулсан хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа баримт бичгүүд:</p> <ul style="list-style-type: none"> - Техникийн зохицуулалт-4, - Барилгын норм ба дүрэм – 195, - Стандарт – 637,
--	--	--	--	--	---

						<p>- Барилгын дүрэм, заавар, цомог, аргачлал, бусад - 230 баримт бичгийг олон нийтэд түгээн сурталчилж, эх хувиар үзэх боломжийг бүрдүүлсэн.</p> <p>- Салбарт хүчин төгөлдөр мөрдөгдөж https://mcis.gov.mn/ веб сайтад байршуулсан баримт бичиг тус бүрт түүвэрлэн орж үзэхэд эрэлт хэрэгцээ шаардлагаасаа хамаарч үзэлтийн тоо янз бүр бөгөөд хамгийн багадаа 50-80, хамгийн их нь 537-1850 удаагийн хандалт хийгдсэн байна.</p>	
3.	<p>1.2. Зөвлөлийн үйл ажиллагааны болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй холбоотой салбарт тулгамдаж буй асуудлын талаар “Асуудал-шийдэл” хэлэлцүүлгийг зохион байгуулах. (ХБХЭХЗҮАТ - 21)</p>	<p>- ХНХЯ болон бусад хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөл, холбогдох байгууллагуудтай хамтран хэлэлцүүлэг, зөвлөгөөн, уулзалт зохион байгуулсан байна.</p>	<p>Хэлэлцүүлэг, зөвлөгөөн, уулзалтын тоо</p>	<p>I-IV улиралд</p>	<p>БХБЯ, ХНХЯ, БХТ ТӨААТҮГ, ТББ-ууд</p>	<p>- ХНХЯ-аас 2023.04.14-ний өдөр зохион байгуулсан “Саадгүй байдал, хүртээмжийн тухай хууль”-ийн хэлэлцүүлэгт Хөгжлийн бодлого, газрын харилцаа, хот байгуулалтын газрын дарга, Барилга, инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын шинжээч нар оролцсон. Тус 2 хуулийн төсөлд санал өгсөн.</p> <p>- ХНХЯ-аас болон бусад хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөл, холбогдох байгууллагуудтай хамтран хэлэлцүүлэг, зөвлөгөөн, уулзалт зохион 2023 оны 05 дугаар сарын 23-ны байгуулсан. Үүнд барилга хот байгуулалтын яамнаас Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг төрөөс орон сууцаар хангахад дэмжлэг үзүүлэх хөтөлбөр”-ийг төслийг боловсруулан танилцуулж санал авсан.</p>	100

					<p>- Барилга, хот байгуулалтын сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 164, А/102 хамтарсан тушаалаар баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг төрөөс орон сууцаар хангахад дэмжлэг үзүүлэх хөтөлбөр”-ийг 2024-2026 онд хэрэгжүүлэх ажлыг хамтран зохион байгуулж, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг халамжийн болон түрээсийн орон сууцны хөтөлбөрт хамруулах чиглэлд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна.</p> <p>- Барилга байгууламжийн норм нормативын сангийн үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөөний 178-д Салбарын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, сайжруулах /Барилгын тухай хуулийн хяналт, шинжилгээ, үнэлгээ/ ажлыг тусгаж батлуулсан бөгөөд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу “Монголын барилгын инженерүүдийн холбоо” ТББ шалгарч БХТ ТӨААТҮГ-ын захирлын 2023 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн 2023/148 дугаартай гэрээг байгуулж ажлыг эхлүүлсэн.</p> <p>- Энэ ажлын хүрээнд Барилгын тухай хуулийн төсөл болон түүнийг дагаж гарах дүрэм, журамд санал авч хамтран ажиллахаар зохион байгуулалтын ажлыг хийж байна. Шинэчилсэн найруулгын үзэл</p>
--	--	--	--	--	--

						<p>баримтлал эхлэлийн тайлан ирүүлсэн бөгөөд гэрээт ажлын зөвлөх үйлчилгээний санхүүжилт болох 30 хувийг Барилга байгууламжийн норм, нормативын сангаас татан авч “Монголын барилгын инженерүүдийн холбоо” ТББ-д олгох ажлыг зохион байгуулан шийдвэрлэсэн.</p> <p>- Барилгын ерөнхий хуулийн /шинэчилсэн найруулга/ төслийн үзэл баримтлалд:</p> <p>- Барилгын салбарын мэргэжилтний мэргэжлийн ур чадварыг баталгаажуулан зэрэг дэв олгох, гэрчилгээжүүлэх үйл ажиллагааг төрийн бус мэргэжлийн холбоодод бүрэн хариуцуулах, мэргэжлийн холбоод нь мэргэжилтний мэргэжлийн баталгааг гаргаж, мэргэжлийн болон ёс зүйн алдаа гаргасан тохиолдолд хамт хариуцлага хүлээх, мэргэжилтний мэргэжлийн зэрэг, дэв, үнэмлэхийг хүчингүй болгох зэрэг зохицуулалтыг хуульд тусгах, мэргэжилтний эрх зүйн байдлыг зохицуулалтын хувьд шинэ түвшинд гаргахыг зорьж дөрөвдүгээр бүлгийг боловсруулж байна.</p> <p>- Дөрөвдүгээр бүлэг. Барилгын салбарын мэргэжилтний эрх зүйн байдал, бусад оролцогчдын талаарх энэхүү бүлэгт барилгын салбарын мэргэжлийн болон бусад оролцогчдыг тодорхойлж, тэдгээрийн эрх зүйн байдлыг тусгах бөгөөд барилгын салбарын мэргэжилтний эрх зүйн</p>
--	--	--	--	--	--	---

						<p>байдлыг хууль, эрх зүйн хувьд шинэчилсэн түвшинд хүргэж, олон улсын жишигт нийцүүлнэ. Тухайлбал, энэ салбарт оролцогч захиалагч, хөрөнгө оруулагч нарын чиг үүрэг, хариуцлагыг тодорхой тусгаж, мэргэжлийн оролцогчид болох зураг төсөл боловсруулагч, барилгын ажил гүйцэтгэгч, инженер, техникийн ажилтнуудын эрх зүйн байдал, чиг үүргийг тус тус зохицуулна. Барилгын үйл ажиллагаа дах ашиг сонирхлын зөрчил, барилгын салбарын мэргэжилтэй ажилтны мэргэжлийн гэрчилгээ, мэргэшлийн зэрэг, сонгон шалгаруулалт, гэрчилгээжүүлэлтийн талаар тусгах бөгөөд тус салбарын төрийн бус мэргэжлийн байгууллага, эрх зүйн байдлыг хуульчлан зохицуулна. Түүнчлэн, барилга байгууламжийг ашиглагч, өмчлөгч, эзэмшигчийн эрх, үүрэг, зөвлөх үйлчилгээ үзүүлэгч, барилгын салбарт ажиллах гадаадын иргэн, хуулийн этгээдийн асуудлыг авч үзэхээс гадна мэргэжилтний хариуцлагын даатгалын зохицуулалт, ёс зүйн дүрмийн талаар тус бүлэгт тусгана.</p>	
Зорилт 2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний ажиллж амьдрах орчин, нөхцөлийг сайжруулах:							
4.	2.1.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн амьдралд саадгүй оролцох,	- Салбарын норм, нормативын баримт бичигт үзлэг хийх, норм нормативын цахим санг	- Салбарын норм нормативын баримт бичигт үзлэх	I-IV улиралд	БХБЯ, БХТ ТӨААТҮГ, ТББ-ууд	- Ажлын хэсгийн хүрээнд “Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн хэрэгжилтийн түвшин тогтоох үзлэг” хийх ажлын техникийн даалгаврыг	50

	хүртээмжийг сайжруулах эрх зүйн орчинг бүрдүүлэх чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах. (ЗГҮАХХАХТ-2.5.8)	сайжруулж, хөгжүүлэх техникийн шийдэл гаргах, ажлын даалгавар, санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллах. - Барилга, хот байгуулалтын салбарт хамаарах хүртээмжтэй холбоотой хууль тогтоомжууд, тэдгээрт тусгагдсан заалтуудын жагсаалтыг гарган дүгнэлт хийж, холбогдох арга хэмжээг авна.	хийх ажлын хэсэгт орж ажилласан байна. Ажлын хэсгийн дүгнэлт зөвлөмж гарсан байна. - ХБИ-нд хүртээмжтэй холбоотой эрх зүйн баримт бичгүүдийн жагсаалт-1.			Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр 34/2023 дугаараар батлуулсан.	
5.	2.2. Түрээсийн орон сууцны хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хамрагдалтын хувийг нэмэгдүүлэх асуудлыг шийдвэрлүүлэх.	- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс түрээсийн орон сууцанд хамрагдалтын хувийг нэмэгдүүлнэ.	түрээсийн орон сууцанд хамрагдалт 15 хувьд хүрнэ.	II-IV улиралд	БХБЯ ХНХЯ, Сангийн яам, ТББ-ууд	- Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.4.3-т/ Залуу гэр бүл, 18 хүртэлх насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй гэр бүлийг тэргүүн ээлжид орон сууцжуулах, орон сууцны түрээсээ урьдчилгаанд шилжүүлэн тооцуулдаг арга хэмжээг үе шаттай нэвтрүүлнэ./ гэж заасныг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 138 дугаар тогтоолоор "Түрээсийн орон сууцыг өмчлүүлэх журам"-ыг батлагдсан. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд улсын төсөв, олон улсын байгууллага, хандивлагч	100

					<p>орнуудын буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр түрээсийн орон сууцны сан бүрдүүлэн гэр хорооллыг дахин төлөвлөх, орон сууцны хороолол барих замаар тусгай хэрэгцээ шаардлагатай иргэд, харж хандах үр хүүхэдгүй ахмад настан, залуу гэр бүл, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, байгалийн давагдашгүй хүчин зүйлийн нөлөөгөөр гэр оронгүй болсон айл өрх, төрийн албан хаагч, олон хүүхэдтэй гэр бүл зэрэг тодорхой тооны зорилтод бүлгийн иргэдийг хөнгөлөлттэй үнээр түрээсийн байраар хангах болсон.</p> <p>- Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 38, 169, 298 дугаар тогтоолуудаар нийслэлийн хэмжээнд 787 айлын орон сууц, орон нутагт 733 айлын орон сууц буюу нийт 1520 айлын орон сууцыг Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор Төрийн өмчийн түрээсийн орон сууцны санд шилжүүлж, эдгээр орон сууцад холбогдох журмын шаардлага хангасан иргэдийг бүрэн хамруулсан. Өнөөгийн байдлаар нийт 1520 айлаас 9 орон сууцыг иргэд бүрэн төлбөрийг барагдуулан өөрсдийн эзэмшилд 100% шилжүүлээд байгаа бол түрээслээд өмчлөх гэрээг 883 иргэн хийгээд байна.</p> <p>- “Түрээсийн орон сууцыг өмчлүүлэх журам”-ын 2.2.1, 2.2.2-т зааснаар хүсэлт гаргасан иргэд нь 5 хүртэлх жилийн хугацаанд байрны үнийн 30</p>
--	--	--	--	--	---

					<p>хувийг бүрдүүлж, үлдэгдэл 70 хувьд ипотекийн зээлд хамрагдуулах эсхүл орон сууцны нийт үнийг 5 жилдээ хуваан төлж барагдуулах хоёр төрлөөр гэрээ байгуулж байна.</p> <p>- Зорилтот бүлгийн иргэдийг орон сууцанд хамруулах ажлыг 2016 оны “Иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах журам”-ын дагуу болон 2017 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн Барилга, хот байгуулалтын сайдын 25 дугаар тушаалаар шинээр батлагдсан “Зорилтот бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах журам”-ын дагуу хамруулж, 1м.кв талбайн түрээсийн төлбөрийг нийслэлд 6,000 төгрөг, орон нутагт 4,500 төгрөгөөр иргэдэд түрээсэлж байна.</p> <p>- Түрээсийн орон сууцанд иргэдийг дараах ангилал, квот /хувь/-ийн дагуу хамруулсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Хувийн байгууллагад ажиллагсад болон хувиараа хөдөлмөр эрхлэгч 367 айл буюу 24%; - Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, түүнийг халамжилдаг гэр бүл 91 айл буюу 6%; - Төрийн албан хаагч 398 айл буюу 26%; - Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон ахмад настан 296 айл буюу 20%; - Гамшиг, аюулт үзэгдлийн улмаас орон гэргүй болсон иргэн 36 айл буюу 2%; 	
--	--	--	--	--	--	--

						<ul style="list-style-type: none"> - Залуу гэр бүл 239 айл буюу 16%; - 18 хүртэлх насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй гэр бүл 14 айл буюу 1%; - Өрх толгойлсон эцэг, эх 79 айл буюу 5% тус тус байна. - Нийслэлийн орон сууцны корпораци ХК-ийн хэрэгжүүлсэн “Ахмадыг орон сууцжуулах”, “Түр суурьшуулах, түрээсийн олон талт хөтөлбөр”, “Орлогод нийцсэн орон сууц”, “Их засварын барилга орон сууц”, “Налайх дахин төлөвлөлт”, “Ногоон орон сууц”, “Ковидын онцгой нөхцөлийн орон сууц”, “Нийслэлийн төрийн албан хаагчийн орон сууц”, “Гадипийн 20 айл”, “Түншлэлийн орон сууц орон сууц” -зэрэг төсөл, хөтөлбөрийн хүрээнд 2015-2023 онд нийт 3848 иргэдийг түрээслээд өмчлөх, түр суурьшуулах түрээслээд өмчлөх /энгийн түрээс, газар чөлөөлөлт/ тус тус түрээсийн хэлбэрээр нь хамруулсан байна. Үүнээс 2023 онд нийт 583 иргэд хамрагдсанаас 30 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хамруулсан байна. 	
6.	2.3.Ипотекийн зээлийн шаардлагыг хангасан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг уг зээлд хамруулах, дарааллыг	- Хүсэлт гаргасан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ипотекийн зээлд хамруулах чиглэлд дэмжлэг үзүүлнэ.	Зээлд хамрагдсан иргэдийн тоо	II-IV улиралд	БХБЯ-ны ТББ-ууд	- “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хүрээнд ипотекийн 3-6 хувийн зээлийн санхүүжилтийг нэмэгдүүлэн ажиллаж байгаа бөгөөд 2023 оны 12 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар арилжааны	100

	<p>урагшлуулах зэрэг чиглэлд дэмжлэг үзүүлэх.</p>					<p>банкуудад нийт 2,009.4 тэрбум төгрөгийн ипотекийн зээлийн хүсэлт ирснээс 799.2 тэрбум төгрөгийн ипотекийн зээлийг 7,665 зээлдэгчид олгоод байна. Үүнээс 69.1 хувь буюу 552.5 тэрбум төгрөгийн 4,605 зээлийг Улаанбаатар хотод олгосон бол 30.9 хувь буюу 246.7 тэрбум төгрөгийн 3,060 зээлийг орон нутагт олгосон байна. Мөн тус хугацаанд гарсан 799.2 тэрбум төгрөгийн зээлийн 640.2 тэрбум төгрөг нь Монголбанкны эх үүсвэрээс, 159.0 тэрбум төгрөг нь арилжааны банкуудын өөрийн эх үүсвэрээс санхүүжсэн байна.</p> <p>- Цаашид ипотекийн зээлийн хөтөлбөрийг хөдөө, орон нутагт илүү тогтвортой хэрэгжүүлэх хүрээнд “Хот хөдөөгийн сэргэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 68 дугаар тогтоолоор Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьшсан болон Улаанбаатар хотын алслагдсан дүүрэг Багануур, Багахангайд анх удаа орон сууц худалдан авах иргэдэд арилжааны банкнаас олгох ипотекийн 3 хувийн хүүтэй хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн ерөнхий гэрээг байгуулж, үйл ажиллагааг нь эрчимжүүлэхийг Монгол банкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэнд зөвлөж, Сангийн сайд Б.Жавхланд даалгасны дагуу орон нутгийн ипотекийн 3 хувийн</p>
--	---	--	--	--	--	---

					<p>хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн ерөнхий гэрээний төсөлд Монголбанк, БХБЯ, ЗБДС болон арилжааны банкуудын саналыг авч тусган боловсруулж, гарын үсэг зурж баталгаажуулан 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрөөс хэрэгжүүлж эхлээд байна.</p> <p>- 2023 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн байдлаар хөдөө, орон нутагт ипотекийн 3 хувийн 157.3 тэрбум төгрөгийн 2,334 зээлийн хүсэлт арилжааны банкуудад ирснээс 820 хүсэлтийг шийдвэрлэн 68.0 тэрбум төгрөгийн зээл олгож, 405 хүсэлтийн 38.3 тэрбумын төгрөгийн зээлийг шийдвэрлэгдэхээр судлагдаж байна.</p> <p>- Олгогдсон зээлийн дийлэнх хувийг Орхон /23.8%/, Дархан-Уул /13.2%/, Дорнод /9.6%/ аймгуудад олгогдоод байна. Нийт зээлд хамрагдсан 820 зээлдэгчийн 789 нь тухайн орон нутагтаа амьдардаг иргэд хамрагдсан бол 31 зээлдэгч Улаанбаатар хотоос орон нутагт шилжин зээлд хамрагдсан байна.</p> <p>- Мөн Зээлийн батлан даалтын сангаар дамжуулан 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар хөдөө, орон нутгаас ипотекийн зээлд хамрагдсан 179 зээлдэгчийн 2,867.3 сая төгрөгийн урьдчилгаа төлбөрт батлан даалт гаргаж, ипотекийн зээлд хамрагдахад нь дэмжлэг үзүүлээд байна.</p>
--	--	--	--	--	--

7.	<p>2.4. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг төрөөс орон сууцаар хангахад дэмжлэг үзүүлэх хөтөлбөр”-ийг батлуулж, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг халамжийн болон түрээсийн орон сууцны хөтөлбөрт хамруулах чиглэлд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах. (ХБХЭХЗҮАТ - 4)</p>	<p>- Холбогдох эрх зүйн болон бусад судалгааны ажлуудыг хийж холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж, батлуулсан байна.</p>	<p>Хөтөлбөр, төлөвлөгөө тус бүр 1 баримт бичиг.</p>	<p>I-IV улиралд</p>	<p>БХБЯ, ХНХЯ, СЯ, ТББ-ууд</p>	<p>- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг төрөөс орон сууцаар хангахад дэмжлэг үзүүлэх хөтөлбөр”-ийг боловсруулан, батлуулах ажлын хүрээнд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төрийн бус байгууллага болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас эцсийн байдлаар санал авч нэгтгэсэн ба хөтөлбөрийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд болон болон Барилга, хот байгуулалтын сайдын 2023 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 164/А/102 дугаар хамтарсан тушаалаар 2024-2026 онд хэрэгжүүлэхээр батлуулаад байна.</p> <p>- Уг хөтөлбөрийн хүрээнд хөдөлмөр эрхэлж, орлого олдог хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг төрөөс хэрэгжүүлж буй орон сууцны бодлого, төсөл хөтөлбөрт тэргүүн ээлжид хамруулах, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй өрхийг орон сууцны дэмжлэгт хамруулах чиглэлээр 4 зорилтын 15 үйл ажиллагааг тодорхойлсон бөгөөд түүний хэрэгжилтийг хангах, “Орон сууцны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн журам”, “Зорилтот бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах журам”-д холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулахаар ажиллаж байна.</p> <p>- Үүнтэй холбогдон ХНХЯ-ны чиг үүрэгтэй холбоотой уг хөтөлбөрийн</p>	<p>100</p>
----	---	---	---	---------------------	--------------------------------	---	------------

						4.1.2, 4.1.3, 4.1.4, 4.4.5-д заасан үйл ажиллагааны талаарх дараах мэдээллүүд шаардлагатай байгаа тул хөтөлбөрт хамрагдах хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон түүнийг асран хамгаалагч, гэр бүл, өрхийг тодорхойлж, мэдээллийн сан үүсгэх замаар хэрэгжүүлэгч байгууллагуудыг бодит мэдээллээр тогтмол хангах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, төлөвлөгөөний талаарх саналаа дээрх шаардлагатай судалгаа, мэдээллийн хамт гарган хамтран ажиллах талаар ХНХЯ-д 2023 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 3/3761 тоот албан бичгийг хүргүүлээд байна.	
Зорилт 3. Орон сууц, олон нийтийн барилга байгууламж, дэд бүтцийн байгууламжийг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагад нийцүүлэх:							
8.	3.1.Барилга байгууламжийн зураг төсөл, ажлын даалгаварт ХБИ-д зориулсан тусгай шаардлага, холбогдох норм ба дүрэм, стандартуудыг тусгаж, хэрэгжүүлэх, хяналт тавин ажиллах. (Барилгын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.6 дэх заалт, 15 дугаар	- "Барилга, байгууламжид хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүртээмжийг төлөвлөх" /БНБД 35-01-22/ барилгын норм ба дүрмийн дагуу зураг төсөл боловсруулах, магадлалын дүгнэлтээр баталгаажуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна.	- Магадлалын дүгнэлтээр баталгаажсан зураг төслийн тоо 1. Тайлангийн хэрэгжилтийн хувь.	I-IV улиралд	ГЗБГЗЗГ, БХТ ТӨААТҮГ, МЗТЗХ ТББ, ТББ-ууд, ААН-үүд	- Барилгын тухай, Хот байгуулалтын тухай хуулийн дагуу Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ нь хот төлөвлөлт, барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх шатанд "Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм" /БНБД 30-01-04/, "Барилга, байгууламжид хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүртээмжийг төлөвлөх" /БНБД 35-01-22/, "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн гарын авлага" /БД 31-101-04/, "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орон зай, орчны зураг төсөл төлөвлөлт" /БД 31-112-11/	100

	заалт, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 9 дүгээр зүйл)	- БХТ-ийн Магадлалын хэлтэс тайлангаа БХБЯ-ны удирдлагын зөвлөл, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд зөвлөлийн хуралдаанд хагас жил тутамд тавьж, хэлэлцүүлнэ.				болон холбогдох бусад норм, стандартын шаардлагыг хангуулан хянаж баталгаажуулан ажиллаж байна. - Засгийн газрын 2019 оны 108 дугаар тушаалаар батлагдсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”-ийг дагуу улсын хэмжээнд улс орон нутаг, хувийн хөрөнгө оруулалтаар 2019-2023 онд хот байгуулалтын баримт бичиг, ТЭЗҮ, барилга байгууламжийн нийт 10401 зураг төсөлд магадлал хийж ажилласан байна. Үүнээс улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 6917 , хувийн хөрөнгө оруулалтаар 3473 , Гадаадын заал тусламжийн хөрөнгөөр 11 зураг төсөлд магадлал хийгдсэн байна. - 2023 оны жилийн эцсийн байдлаар улсын хэмжээнд нийт 769 барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийгдсэн байна. Үүнээс 320 орчим орон сууцны барилгын зураг төсөлд магадлал хийсэн байна.	
9.	3.2.Хөгжлийн бэрхшээлтэй хүнд барилга байгууламж, дэд бүтцийн хүртээмжийн үзлэг, барилга байгууламжийн засвар үйлчилгээний ажлыг	- Барилга байгууламжуудад үзлэг хийж, шаардлага хангахгүй барилга байгууламжийг ХБИ-д хүртээмжтэй болгон шинэчлэх асуудлыг шийдвэрлэн хэрэгжүүлсэн байна.	- Үзлэгт хамруулсан барилгын тоо; - ХБИ-ийн хэрэгцээнд нийцүүлэн засварласан	I-IV улиралд	БХБЯ ГЗБГЗЗГ, БХТ ТӨААТҮГ, ААН, ТББ-ууд	- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангахад чиглэсэн асуудлыг салбарын хяналтын хуудсанд тусган хамтран хэрэгжүүлсэн ажлын хэрэгжилтийг гарган холбогдох газарт нь 2023 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр хүргүүлсэн. - “Салбартаа болон харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд дэд бүтэц, мэдээллийн хүртээмжийн үнэлгээг	100

<p>нийслэл, орон нутагт үргэлжлүүлэн хэрэгжүүлэх. (Барилгын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.6 дэх заалт, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 8, 9 дүгээр зүйл) (ХБХЭХЗҮАТ - 6)</p>	<p>- 20-оос доошгүй байгууллагын хүртээмжтэй байдлыг сайжруулсан байна. - Яам, харьяа байгууллагуудын вэб сайтуудыг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй болгох чиглэлд ажиллана.</p>	<p>барилгын тоо.</p>			<p>төрийн бүх шатны байгууллагад 2023 онд багтаан хийж, 50-иас доошгүй хувийг нь хүртээмжтэй болгох” ажлын хүрээнд Барилга, хот байгуулалтын сайдын А/230 дугаар тушаалаар Нийслэл дэх зарим төр, захиргааны барилга байгууламжид холбогдох норм, дүрэм, стандартад нийцсэн эсэхэд үнэлгээ хийж, саадгүй байдал, хүртээмжийг бий болгох талаар санал, дүгнэлт, зөвлөмж гаргах үүрэг бүхий Дэд ажлын хэсгийг, Төрийн нарийн бичгийн даргын А/169 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтаар Есөн /9/ яамны барилга байгууламжид саадгүй байдал, хүртээмжийн үнэлгээ хийж, санал, дүгнэлт, зөвлөмж бүхий тайлан гаргах үүрэг бүхий багийн бүрэлдэхүүнийг томилон, 4 дүгээр хавсралтаар “Нийслэл дэх төр захиргааны байгууллагуудын зарим барилгуудын саадгүй байдал, хүртээмжийн байдлын үнэлэх хуудас”-ыг тус тус баталсан. - Батлагдсан үнэлгээний хуудасын дагуу холбогдох барилга байгууламжид саадгүй байдал, хүртээмжийн үнэлгээ хийж, үнэлгээний тайланг нэгтгэн, үнэлгээний илтгэх хуудасыг санал, дүгнэлт, зөвлөмжийн хамт Боловсрол, шинжлэх ухааны яам, Гадаад хэргийн яам, Эрүүл мэндийн яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Цахим хөгжил харилцаа холбооны яам, Эрчим хүчний яам, Батлан</p>
---	--	----------------------	--	--	--

						хамгаалах яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Соёлын яам зэрэг 9 яамд болон Сонгинохайрхан, Сүхбаатар, Чингэлтэй, Хан-Уул дүүргүүдийн Засаг даргын тамгын газарт 2023 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 9/406, 9/407, 9/408, 9/409 дугаар албан бичгээр тус тус хүргүүлсэн.	
10.	1.3. Батлагдсан зураг төслийг давтан хэрэглэх болон нэг маягийн зураг төслийг холболт хийх, хүртээмжтэй байдлын үнэлгээ хийж, холбогдох арга хэмжээг авах.	- “Батлагдсан зураг төслийг давтан хэрэглэх болон нэг маягийн зураг төслийг холболт хийх журам”-ын төсөл боловсруулж, батлуулсан байна.	- Батлагдсан журам; - ХБИ-ийн саналын тоо.	I-IV улиралд	БХБЯ, БХТ ТӨААТҮГ, ТББ-ууд	- БХБС-ын 2019 оны 54 дүгээр тушаалаар батлагдсан “Батлагдсан зураг төслийг давтан хэрэглэх болон нэг маягийн зураг төсөлд холболт хийх журам”-ын төслийг шинэчлэн боловсруулан, төсөлд холбогдох байгууллагаас санал авч тусгасан. - Журмын төслийг эцэслэх ажлыг Засгийн газрын 108 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”-ийн шинэчлэлтэй уялдуулах ажлыг зохион байгуулсан. - Мөн “Барилга байгууламжийн нэг маягийн зураг төслийн мэдээллийн систем” хөгжүүлж, нэвтрүүлэх зөвлөх үйлчилгээний ажлын даалгавар”-ыг батлуулсан. Нэг маягийн зургийн мэдээллийн санг холбогдох өргөтгөлүүдийн дагуу бэлтгэн бэлэн болгосон. Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх төсвийн танилцуулгыг бэлтгэж, 2024 оны норм, нормативын санд суулгах ажлыг зохион байгуулсан. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг “Барилгын	70

						хөгжлийн төв” ТӨААТҮГ зохион байгуулан ажиллаж байна.	
11.	3.3. “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ болон харьяа байгууллагуудын “Нэг цэгийн үйлчилгээ”-нд ХБХ-нд дараалал харгалзахгүй үйлчлэх арга хэмжээг хэвшүүлэх.	- Үйлчилгээний хүртээмжийг сайжруулах тэмдэг, шошгыг ашигласан байна. Нийтэд зарласан байна.	Үйлчилгээг хүртээмжтэй болгосон цэгүүдийн тоо.	I-IV улиралд	БХБЯ, ГЗБГЗЗГ, БХТ ТӨААТҮГ, Аймаг, Нийслэлийн ГХБХБГ, ААН, ТББ-ууд	- 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна. - “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ болон харьяа байгууллагуудын “Нэг цэгийн үйлчилгээ”-нд ХБХ-нд дараалал харгалзахгүй үйлчлэх арга хэмжээг хэвшүүлэн, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах тэмдэг, шошгыг байршуулан ажиллаж байна.	100
Зорилт 4. Салбарын болон нийгмийн үйл ажиллагаанд ХБИ-ийн оролцоо ба тэдний хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх хүрээнд:							
12.	4.1.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сургалтад хамруулах, ажлын байраар хангах чиглэлд холбогдох арга хэмжээг авах ба хөдөлмөр эрхлэлтийн судалгаанд хамруулах. (Хөдөлмөрийн тухай хуулийн 144.2)	- ХБИ сургалтад хамрагдаж, ажлын байраар хангагдсан байна. - Салбарын төрийн, төрийн бус, хувийн хэвшлийн байгууллагуудад ажиллаж буй ХБИ-ийн тоо нэмэгдсэн байна. - Харьяа байгууллагуудын хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулах боломжтой сул ажлын байрыг судлан, холбогдох байгууллагатай хамтран зохион	Сургалтын болон ажил эрхлэгч иргэдийг тоо.	II-IV улиралд	БХБЯ-ны ТЗУГ, СМТХ, ХНХЯ, ГЗБГЗЗГ, БХТ	- Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн 144.2 дахь заалтын хэрэгжилт болон Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний “4.1-д заасан Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сургалтад хамруулах, ажлын байраар хангах чиглэлд холбогдох арга хэмжээг авах ба хөдөлмөр эрхлэлтийн судалгаанд хамруулах” ажлын хүрээнд тус яам болон харьяа байгууллагын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг батлагдсан бүтэц, орон тоонд нийцүүлэн ажиллуулж буй талаарх судалгааг 2023 оны жилийн эцсийн байдлаар нэгтгэн гаргаж, ХНХЯ-нд 2023.12.19-	100

		байгуулалт хийж, Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн 144.2-т заасан шаардлагыг биелүүлж ажиллана.				<p>ний өдрийн 3/4601 тоот албан бичгээр хүргүүлж ажилласан.</p> <p>- Уг судалгаагаар Барилга, хот байгуулалтын яам болон харьяа агентлаг, байгууллагуудад 2023 оны жилийн эцсийн байдлаар 25 хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажиллаж байна. Барилга, хот байгуулалтын яамны батлагдсан бүтэц, орон тооны 93 албан хаагчаас 2 албан хаагч хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллаж байгаа бөгөөд хуулийн хэрэгжилтийг хангаж байна.</p> <p>- Барилга, хот байгуулалтын яам болон харьяа агентлаг, байгууллагуудад гэр бүлийн гишүүдийн дотор тусгай арчилгаа шаарддаг хүүхэд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн байдаг болохыг судалгаагаар тодорхойлсон. 5 албан хаагчийн гэр бүлд хөгжлийн бэрхшээлтэй иргэн байна.</p> <p>- Яамны хөдөлмөрийн дотоод журамд дээрх албан хаагчдад шаардлагатай тохиолдолд чөлөө олгох, тусламж, дэмжлэг үзүүлэх заалтыг тусгагдсан. 2023 оны I улирлын байдлаар хөгжлийн бэрхшээлтэй 1 албан хаагчид тусгай арчилгаа, эмчилгээнд зориулж цалинтай чөлөө олгосон.</p>	
13.	4.2.Барилгын үйл ажиллагаанд ХБИ-ийн төлөөллийг оролцуулж байх.	- Барилга байгууламжийн зураг төсөл, баримт бичиг боловсруулах,	- Сургалтад хамрагдсан, барилгын үйл ажиллагаанд	II-IV улиралд	БХБЯ, ГЗБГЗЗГ, БХТ,	- Монгол Улсын Засгийн газрын 2021 оны "Дүрэм шинэчлэн батлах тухай" 212 дугаар тогтоолоор батлагдсан "Барилга байгууламжийг ашиглалтад	100

<p>(Барилгын тухай хуулийн 4.1.20 дах заалт, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 8, 9 дүгээр зүйл)</p>	<p>магадал хийх, барилгын ажил гүйцэтгэх, үе шатны ажилд хяналт тавих, ашиглалтад оруулж, гэрчилгээжүүлэхэд санал авах, оролцоог хангах, саадгүй байдал, хүртээмжийн үнэлгээ хийхэд оролцож ажиллах боломжтой мэргэжлийн зохих чадамжтай хөгжлийг бэрхшээлтэй иргэдийн жагсаалтыг гаргаж, сургалтад хамруулан хүний нөөцийг бүрдүүлж, тус нөөцөд бүртгэлтэй хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг “барилгын үйл ажиллагаа”-нд сонголтоор оролцуулан ажилладаг байх.</p> <p>- Комисст ажиллах ХБИ-д сургалт явуулж, гарын авлага гарган, норм ба дүрэм, үнэлгээ, түүний тайлангийн талаар мэдлэг ойлголтыг өгнө.</p>	<p>оролцох чадамжтай хөгжлийн бэрхшээлтэй хүний нөөцийг бүрдүүлсэн байна.</p> <p>- Комисст ажилласан болон барилгын үйл ажиллагаанд оролцсон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо;</p>		<p>ХБХХЕГ, ТББ-ууд</p>	<p>оруулах дүрэм"-ийн 2.2-т заасны дагуу Барилга байгууламжийн төвөгшлийн ангиллаас хамааран барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комисс томилогдон үзлэг шалгалт хийн ажиллаж үүрэг даалгаврын биелэлтийг хангуулан актыг баталгаажуулан ажиллаж байна. "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийн 1 дүгээр хавсралтад заасны дагуу "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүн"-д комиссын бүрэлдэхүүнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах байгууллагын төлөөллийг гишүүнээр байнга оролцуулан ажиллуулж байна.</p> <p>- Барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын 2008 оноос хойш гарсан дүгнэлт, холбогдох мэдээллийн улсын хэмжээнд нэгтгэн Засгийн газрын шилэн системд /shilen.gov.mn/ оруулах Ажлын хэсэг Барилга, хот байгуулалтын сайдын 2023 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 104 дүгээр тушаалаар байгуулагдаж, 2008-2023 он хүртэлх барилга байгууламжийн комиссын дүгнэлтийн мэдээллийг нэгтгэн бүрдүүлж, Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хүргүүлсэн ба www.shilen.gov.mn цахим хуудсанд нээлттэй байршуулан ажиллаж байна. Үүнд:</p>	
--	---	---	--	------------------------	--	--

					<p>- Улсын хэмжээнд 2008-2023 онд нийт 8437 барилга байгууламжийн улсын комиссын дүгнэлт https://shilen.gov.mn/open-data/tag/ 3 мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэнээс 21 аймагт 4754, нийслэлд 3683 барилга байгууламжийн улсын комиссын дүгнэлт тус тус бүртгэгдсэн байна.</p> <p>- Үүнээс 2020-2023 онд 21 аймагт нийт 1522, орон сууцны барилга 308, нийслэлд нийт 930, орон сууцны барилга 167 тус тус улсын комиссын дүгнэлт бүртгэгдсэн байна.</p> <p>- Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм” хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойш магадлал хийгдсэн улс орон нутаг, хувийн хөрөнгө оруулалтаар 2019-2023 онд хот байгуулалтын баримт бичиг, ТЭЗҮ, барилга байгууламжийн нийт 10401 зураг төсөлд магадлал хийж ажиллсан байна. Үүнээс улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 6917, хувийн хөрөнгө оруулалтаар 3473, Гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр 11 зураг төсөлд магадлал хийгдсэн байна.</p> <p>- 2023 онд нийт 769 барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийгдэж баталгаажсан байна. Үүнээс улсын төсвийн хөрөнгөөр 575, хувийн хөрөнгө</p>
--	--	--	--	--	--

						оруулалтаар 194 зураг төсөлд магадалал хийсэн байна.	
14.	4.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургууль, цэцэрлэгт сурч боловсроход шаардлагатай орчин бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх. (Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 5 дугаар зүйл, 15 дугаар зүйлийн 15.1.2)	- Аймаг, Нийслэлийн тусгай хэрэгцээтэй сургуулийн сурагчдийн хэрэгцээнд нь тохирох ном, сурах бичиг, гарын авлага, материал, тусгай хэрэглээний сургалтын тоног төхөөрөмж, хэрэгслээр дэмжлэг үзүүлсэн байна.	Дэмжлэг үзүүлсэн ажил, тоног төхөөрөмжийн тоо.	II-IV улиралд	БХБЯ, ГЗБГЗЗГ, БХТ ТӨААТҮГ, ТББ-ууд	Барилга, хот байгуулалтын яам болон Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын захиалгаар “Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо” ТББ-аас “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүртээмжтэй, хэрэгцээ шаардлагад нийцсэн барилга байгууламжийн төлөвлөлтөд тавигдах шаардлага” нормативын баримт бичгүүдийг нийтэд сурталчлан таниулах анимейшныг бэлтгэн нийтийн хүртээл болгосон. - Сургуулийн барилгын сургалтын орчны хүртээмжтэй байдлыг сайжруулах шаардлага” жишиг баримт бичиг, техникийн дүрэм боловсруулах ажлын техникийн даалгавар 2023 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 19/2023 дугаартай батлагдсан. БХТ ТӨААТҮГ-ын захирлын 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А/285 тушаалаар үнэлгээний хороо байгуулагдан сонгон шалгаруулах ажлыг гүйцэтгэсэн. - Мөн "Барилга байгууламжийн норм, нормативын сангийн үйл ажиллагааны 2019-2023 оны төлөвлөгөө"-ний дагуу барилгын нэгдсэн мэдээллийн системд https://mcis.gov.mn/mn/norm салбарын норм нормативын баримт бичгийг байршуулсан нь инженер техникийн	80

						<p>ажилчид интернэттэй орчинд тухайн ажлын байрнаас шууд хэрэглэх, судлах, санал зөвлөмж өгөх, мөрдөх зэрэг боломжийг бий болгосон юм.</p> <ul style="list-style-type: none"> - "Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилгын төлөвлөлт" /БНБД 31-24-22/-7ш, - "Ерөнхий боловсролын сургуулийн барилгын төлөвлөлт" /БНБД 31-25-22/-4ш, - "Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх" /БНБД 22-01-21/ - 5 ш постерыг тус тус байршуулсан байна. <p>Видео бичлэг:</p> <ul style="list-style-type: none"> - "Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүртээмжийг төлөвлөх" /БНБД 35-01-22/-3 удаагийн цуврал бичлэг, - Норм нормативын төсөлд санал өгөх зааварчилгаа-1 удаагийн видео бичлэгийг олон нийтийн сүлжээнд байршуулсан. 	
Зорилт 5: ХБИ-ийн бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлах, худалдан авалтыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх.							
15.	<p>5.2. "Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй бүтээн байгуулалтын төрөлд оны шилдэг"-ийг шалгаруулах арга хэмжээг зохион байгуулж, холбогдох байгууллагад хүргүүлэх. (“Хөгжлийн</p>	<p>- Салбарын бүтээн байгуулалтуудаас хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй шилдгийг шалгаруулж, ХНХЯ-нд хүргүүлсэн байна.</p>	<p>1 доошгүй байгууллага /ААН</p>	<p>IV улиралд</p>	<p>БХБЯ, ХНХЯ, БХТ</p>	<p>1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 01 дугаар тогтоолоор батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй оны шилдэг шалгаруулах журам”-ын 4.1.6-д заасны дагуу “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй бүтээн байгуулалт”-ын төрөлд 2023 оны шилдэг байгууллага, аж ахуйн</p>	100

	бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй оны шилдгийг шалгаруулах журам"-ын 2.1.7) (ХБХЭХЗҮАТ - 24)					нэгжийг шалгаруулах ажлыг зохион байгуулахаар ажиллаж байна. Иймд нэр дэвшүүлэх барилга байгууламж, бүтээн байгуулалтын ажил, төслийг БХБЯ-ны дэргэдэх Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөлийн гишүүдээс авсан. Үүний дагуу Зөвлөлийн гишүүд өөрийн байгууллага болон харьяа байгууллагаас тайлангаа ирүүлж, "Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй бүтээн байгуулалт"-ын төрөлд нэр дэвшүүлэх төсөл, Дэд зөвлөлийн 2024 оны ажлын төлөвлөгөөнд тусгах арга хэмжээ саналыг тус тус бэлтгэн 2023 оны 12 дугаар сарын 20-ны дотор ирүүлээд байна. Ирүүлсэн төслүүдээс "Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй бүтээн байгуулалтын төрөлд оны шилдэг"-ийг шалгаруулах арга хэмжээг зохион байгуулж, хүргүүлэхээр ажиллаж байна.	
16.	5.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээний борлуулалтад дэмжлэг үзүүлэх. (ХБХЭХЗҮАТ -25)	- Үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг ашиглах зорилтот худалдан авалтад дэмжлэг үзүүлнэ.	Бүтээгдэхүүн ий сурталчилгаа , худалдан авалтын тоо.	II-IV улиралд	БХБЯ-ны ТЗУГ, ГЗБГЗЗГ, БХТ ТӨААТҮГ, ТББ-ууд	- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах болон тэдний үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажлын хүрээнд харааны бэрхшээлтэй уран бүтээлч МУГЖ ая зохиогч дуучин Ч.Амаржаргалын "Нартад ганцхан ээждээ" нэртэй уран бүтээлтийн тайлан тоглолтын билет борлуулалтад дэмжлэг үзүүлэн	100

						зөвлөлийн гишүүд болон салбар зөвлөл, яамны албан хаагчид 20 ширхэг билет худалдан авсан ба нийт 800.0 төгрөгийн хандив, дэмжлэг үзүүллээ.	
Нийт 5 зорилт, 16 арга хэмжээ төлөвлөв.						Биелэлт:	93.75

ТАНИЛЦСАН:
ТНБД-ЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

ХЯНАСАН:
ББМУБХЗГ-ЫН ДАРГА

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
ББМУБХЗГ-ЫН ШИНЖЭЭЧ

 Ц.БАЯРБАТ
 Д.ГАНТУЛГА
 Б.ГАНДОЛГОР